

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын Залуучууд театрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/54/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.Shinjlenmagadlahui.ezshaudit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089, 99023682 Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК Утас: 99197346, 88114867 Цахим хаяг: Shinjlenmagadlahui.audit@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 137

танай _____ -ны № _____ -т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН
СУМЫН ЗАЛУУЧУУД ТЕАТРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ М.ЕРБОЛОТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Залуучууд театрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дархан-Уул аймгийн Залуучууд театрын 2025 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 77.01 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх НДШ 9.6 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3.83 хувийг хангамж бараа материалын зардал, 0.64 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж, 3.03 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4526030229

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сараас төсөвт тодотгол хийж 17% бууруулснаар ур чадварын нэмэгдэл 3, 4-р улиралд олгогдоогүй болно.

Бусад асуудал

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулах болно.

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Залуучууд театр нь байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгасан 10 зорилтын хүрээнд 70 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилт нь 100.0 хувиар биелэлттэй ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**СТ-1А****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>794,386,635.76</u>	<u>871,986,365.62</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	24,258,277.72	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	24,258,277.72	-
3121	Төгрөг	24,258,277.72	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31218	Ахмадын сангийн харилцах	24,258,277.72	-
33	АВЛАГА	7,470,405.66	9,203,088.60
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	2,601,438.55
33103	ХХОАТ авлага	-	2,601,438.55
33300	Татаас санхүүжилтын авлага	-	906,777.72
335	Бусад авлага	7,470,405.66	5,694,872.33
33520	Хувь хүмүүсээс авах авлага	7,470,405.66	5,694,872.33
34	УРЬДЧИЛГАА	-	88,140.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	88,140.00
35	БАРАА МАТЕРИАЛ	762,657,952.38	862,695,137.02
351	Түүхий эд материал	122,860,314.00	116,394,144.00
35110	Тусгай зориулалттай материал	122,860,314.00	116,394,144.00
354	Хангамжийн материал	639,797,638.38	746,300,993.02
35410	Бичиг хэргийн материал	2,783,760.00	1,380,600.00
35420	Аж ахуйн материал	10,933,223.00	8,874,848.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,800,000.00	1,800,000.00
35440	Түлш, шатах тослох материал	436,963.40	-
35470	Бусад хангамжийн материал	623,843,691.98	734,245,545.02
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,419,823,657.07</u>	<u>6,511,120,317.69</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,419,823,657.07	6,511,120,317.69
392	Биет хөрөнгө	5,110,106,166.89	5,174,132,817.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,551,704,689.00	5,551,704,689.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,377,133,676.09)	(1,655,949,791.69)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	81,840,000.00	18,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(81,840,000.00)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,278,542,758.32	1,637,824,797.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	(431,171,313.72)	(578,811,944.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	69,162,126.76	67,448,566.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,364,728.72)	(27,387,836.97)
39214	Бусад үндсэн хөрөнгө	88,383,425.82	255,794,775.76
39215	Хуримтлагдсан элэгдэл	(51,017,114.48)	(94,490,438.30)

393	Биет бус хөрөнгө	1,309,717,490.18	1,336,987,500.00
39301	Програм хангамж	4,799,900.00	4,799,900.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,282,409.82)	(2,912,400.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,307,200,000.00	1,335,100,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>7,214,210,292.83</u>	<u>7,383,106,683.31</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>7,470,405.66</u>	<u>27,675,194.21</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,470,405.66	27,675,194.21
413	Өглөг	7,470,405.66	27,675,194.21
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	2,601,438.55
41311	Цалингийн өглөг	-	2,601,438.55
4136	Бусад өглөг	7,470,405.66	25,073,755.66
41361	Байгууллагад төлөх өглөг	7,470,405.66	14,719,905.66
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	10,353,850.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>7,206,739,887.17</u>	<u>7,355,431,489.10</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	7,206,739,887.17	7,355,431,489.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,639,841,262.34	2,639,841,262.34
51101	Өмч: - төрийн	2,639,841,262.34	2,639,841,262.34
512	Хуримтлагдсан үр дүн	(880,400,022.82)	(731,708,420.89)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,471,421,341.39)	(880,400,022.82)
51220	Тайлант үеийн үр дүн	591,021,318.57	148,691,601.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,447,298,647.65	5,447,298,647.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>7,214,210,292.83</u>	<u>7,383,106,683.31</u>

СТ-2А

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,696,035,791.90	4,328,122,770.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,436,566,588.84	1,018,044,422.97
120	Нийтлэг татварын бус орлого	1,436,566,588.84	1,018,044,422.97
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	199,359,440.00	159,673,793.92
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	190,772,700.00	153,424,553.92
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,586,740.00	6,249,240.00
120005	Түрээсийн орлого	-	1,102,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,173,826,009.32	711,716,079.05
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	63,381,139.52	145,552,050.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,259,469,203.06	3,310,078,347.80
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,018,477,175.34	3,157,087,847.80
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,018,477,175.34	3,157,087,847.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	112,932,027.72	7,290,500.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	-	7,290,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	92,948,250.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,983,777.72	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	128,060,000.00	145,700,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	128,060,000.00	145,700,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,043,220,688.13	4,173,262,635.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,043,220,688.13	4,173,262,635.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,592,229,592.58	4,045,659,650.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,523,419,836.43	2,678,248,744.10
210101	Үндсэн цалин	1,458,417,718.87	1,604,665,101.07
210102	Нэмэгдэл	740,061,614.76	852,218,245.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	108,762,128.80	85,476,860.00
210104	Урамшуулал	216,178,374.00	135,488,537.69
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	310,927,500.00	306,134,111.90
210201	Тэтгэврийн даатгал	211,430,700.00	207,747,423.65
210202	Тэтгэмжийн даатгал	24,874,200.00	24,206,374.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,437,100.00	13,996,069.06
210204	Ажилгүйдлийн даатгал	12,437,100.00	13,137,121.96
210205	Эрүүл мэндийн даатгал	49,748,400.00	47,047,122.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,136,547.96	131,774,145.13
210301	Гэрэл, цахилгаан	42,686,445.68	69,737,404.13
210302	Түлш, халаалт	64,556,386.84	58,113,481.80
210303	Цэвэр, бохир ус	1,893,715.44	3,923,259.20
2104	Хангамж, бараа материалын зардал	86,675,558.74	108,855,504.36
210401	Бичиг хэрэг	7,361,300.00	3,673,860.00
210402	Тээвэр, шатахуун	6,983,036.60	4,016,963.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,689,232.13	1,839,899.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,584,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,869,565.00	54,666,505.00
210408	Бараа материал акталсны зардал	47,188,425.01	39,207,776.96
210409	Бараа материал шилжүүлсний зардал	-	5,450,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,700,460.00	6,101,750.00
210604	Урсгал засвар	24,700,460.00	6,101,750.00
2107	Томилолт, зочны зардал	2,700,000.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	2,700,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	76,507,271.00	18,715,790.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,146,451.00	14,612,620.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,314,000.00	1,314,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,420.00	155,370.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	84,500.00	94,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,305,100.00	-
210807	Газрын төлбөр	2,506,800.00	2,506,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	458,162,418.45	794,329,604.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,099,810.00	139,578,920.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	424,062,608.45	654,750,684.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	450,991,095.55	128,002,984.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	118,156,137.31	97,720,609.23
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,444,000.00	11,317,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	41,996,337.31	77,103,109.23
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,416,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,299,800.00	9,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	328,153,786.20	30,107,280.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	328,153,786.20	30,107,280.82
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,681,172.04	175,094.87
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,681,172.04	175,094.87
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>652,815,103.77</u>	<u>154,860,135.55</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	61,793,785.20	6,168,533.62
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	61,793,785.20	6,168,533.62
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(61,793,785.20)	(6,168,533.62)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>591,021,318.57</u>	<u>148,691,601.93</u>

СТ-3А

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,458,828,643.06</u>	<u>3,469,752,141.72</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	199,359,440.00	159,673,793.92
120	Нийтлэг татварын бус орлого	199,359,440.00	159,673,793.92
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	199,359,440.00	159,673,793.92
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	190,772,700.00	153,424,553.92
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,586,740.00	6,249,240.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,259,469,203.06	3,310,078,347.80
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,018,477,175.34	3,157,087,847.80
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,018,477,175.34	3,157,087,847.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	112,932,027.72	7,290,500.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах,ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	-	7,290,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	92,948,250.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,983,777.72	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	128,060,000.00	145,700,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	128,060,000.00	145,700,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,709,281,077.07	3,453,510,619.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,709,281,077.07	3,453,510,619.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,258,289,981.52	3,324,600,856.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,523,419,836.43	2,674,686,410.77
210101	Үндсэн цалин	1,458,417,718.87	1,601,102,767.74
210102	Нэмэгдэл	740,061,614.76	852,618,245.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	108,762,128.80	85,476,860.00
210104	Урамшуулал	216,178,374.00	135,488,537.69
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	310,927,500.00	306,134,111.90
210201	Тэтгэврийн даатгал	211,430,700.00	207,747,423.65
210202	Тэтгэмжийн даатгал	24,874,200.00	24,206,374.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,437,100.00	13,996,069.06
210204	Ажилгүйдлийн даатгал	12,437,100.00	13,137,121.96
210205	Эрүүл мэндийн даатгал	49,748,400.00	47,047,122.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,136,547.96	131,774,145.13
210301	Гэрэл, цахилгаан	42,686,445.68	69,737,404.13
210302	Түлш, халаалт	64,556,386.84	58,113,481.80
210303	Цэвэр, бохир ус	1,893,715.44	3,923,259.20
2104	Хангамж, бараа материалын зардал	34,840,832.13	22,097,169.00
210401	Бичиг хэрэг	7,163,200.00	4,664,700.00
210402	Тээвэр, шатахуун	7,200,000.00	1,620,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,693,632.13	1,839,899.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,584,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,200,000.00	13,972,570.00
2105	Нормативт зардал	630,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	630,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,829,020.00	37,580,100.00
210601	Багаж,техник,хэрэгсэл	-	17,580,100.00
210604	Урсгал засвар	22,829,020.00	20,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,700,000.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	2,700,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	117,783,920.00	91,103,170.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	111,888,100.00	87,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,314,000.00	1,314,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,420.00	155,370.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	84,500.00	94,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,840,100.00	-
210807	Газрын төлбөр	2,506,800.00	2,506,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	136,022,325.00	59,725,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	136,022,325.00	59,725,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	450,991,095.55	128,909,762.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	118,156,137.31	97,720,609.23
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,444,000.00	11,317,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	41,996,337.31	77,103,109.23
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,416,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,299,800.00	9,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	328,153,786.20	30,107,280.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	328,153,786.20	30,107,280.82
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,681,172.04	1,081,872.59
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,681,172.04	1,081,872.59
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(250,452,434.01)</u>	<u>(16,241,522.28)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	49,910,800.00	40,499,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	49,910,800.00	40,499,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	49,910,800.00	40,499,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	49,910,800.00	40,499,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(49,910,800.00)</u>	<u>(40,499,800.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(300,363,234.01)	(24,258,277.72)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	324,621,511.73	24,258,277.72
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,258,277.72	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,639,841,262.34	5,447,298,647.65	(1,471,421,341.39)	6,615,718,568.60
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,639,841,262.34	5,447,298,647.65	(1,471,421,341.39)	6,615,718,568.60
Тайлант үеийн үр дүн	-	-	591,021,318.57	591,021,318.57
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,639,841,262.34	5,447,298,647.65	(880,400,022.82)	7,206,739,887.17
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,639,841,262.34	5,447,298,647.65	(880,400,022.82)	7,206,739,887.17
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,639,841,262.34	5,447,298,647.65	(880,400,022.82)	7,206,739,887.17
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	148,691,601.93	148,691,601.93
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,639,841,262.34	5,447,298,647.65	(731,708,420.89)	7,355,431,489.10

ТГ

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт хэтрэлт	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,527,157,400.00	3,439,468,866.03	(107,688,533.97)	96.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,527,157,400.00	3,439,468,866.03	(107,688,533.97)	96.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,394,985,200.00	3,190,575,011.67	(204,410,188.3)	93.97

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,671,762,400.00	2,674,686,410.77	2,924,010.77	100.1
210101	Үндсэн цалин	1,542,784,600.00	1,601,102,767.74	58,318,167.74	103.8
210102	Нэмэгдэл	857,191,800.00	852,618,245.34	(4,573,554.66)	99.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	97,990,000.00	85,476,860.00	(12,513,140.00)	87.23
210104	Урамшуулал	173,796,000.00	135,488,537.69	(38,307,462.31)	77.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	333,970,200.00	306,134,111.90	(27,836,088.1)	91.66
210201	Тэтгэврийн даатгал	227,502,200.00	207,747,423.65	(19,754,776.35)	91.32
210202	Тэтгэмжийн даатгал	26,617,000.00	24,206,374.57	(2,410,625.43)	90.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,308,500.00	13,996,069.06	687,569.06	94.83
210204	Ажилгүйдлийн даатгал	13,308,500.00	13,137,121.96	(171,378.04)	98.71
210205	Эрүүл мэндийн даатгал	53,234,000.00	47,047,122.66	(6,186,877.34)	88.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	168,843,400.00	131,774,145.13	(37,069,254.87)	78.05
210301	Гэрэл, цахилгаан	84,916,300.00	69,737,404.13	(15,178,895.87)	82.13
210302	Түлш, халаалт	80,616,000.00	58,113,481.80	(22,502,518.20)	72.09
210303	Цэвэр, бохир ус	3,311,100.00	3,923,259.20	612,159.20	118.49
2104	Хангамж, бараа материалын зардал	22,600,000.00	22,097,169.00	(502,831.00)	97.77
210401	Бичиг хэрэг	5,900,000.00	4,664,700.00	(1,235,300.00)	79.06
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,620,000.00	(180,000.00)	90.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,900,000.00	1,839,899.00	(60,101.00)	96.84
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,000,000.00	13,972,570.00	972.570	132.42
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,179,900.00	50,179,900.00	(10,000,000.00)	83.38
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,179,900.00	30,179,900.00	-	100.00
210602	Тавилга	10,000,000	-	(10,000,000.00)	
210604	Урсгал засвар	20,000,000.00	20,000,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	114,203,900.00	104,103,170.00	(10,100,730.00)	91.15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	110,000,000.00	100,000,000.00	(10,000,000)	91.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,314,000.00	1,314,000.00	-	100.00

210803	Даатгалын үйлчилгээ	184,500.00	155,370.00	(29,130.00)	84.21
210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,600.00	94,000.00	(49,600.00)	65.46
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	33,000.00	(22,000.00)	60.00
210807	Газрын төлбөр	2,506,800.00	2,506,800.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,925,400.00	51,873,350.00	(52,050.00)	99.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,925,400.00	51,873,350.00	(52,050.00)	99.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102,172,200.00	97,120,609.23	(5,051,590.77)	95.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	102,172,200.00	97,120,609.23	(5,051,590.77)	95.05
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,317,500.00	11,317,500.00	-	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	77,168,700.00	77,103,109.23	(65,590.77)	99.92
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,686,000.00	8,700,000.00	(4,986,000.00)	63.57
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,527,157,400.00	3,439,468,866.03	(107,688,533.97)	96.94
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,191,023,500.00	3,126,980,566.98	(64,042,933.02)	98.92
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,191,023,500.00	3,126,980,566.98	(64,042,933.02)	97.99
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	188,843,400.00	145,524,905.13	(43,318,494.87)	77.06
122005	Орон нутгийн төсвөөс	188,843,400.00	145,524,905.13	(43,318,494.87)	77.06
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	157,290,500.00	166,964,293.92	9,673,793.92	106.15
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000,000.00	153,424,553.92	13,424,553.92	109.58
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,290,500.00	13,539,740.00	(3,750,760.00)	78.30
11000	Мөнгөн хөрөнгө эхний үлдэгдэл	-	-		
12000	Мөнгөн хөрөнгө эцсийн үлдэгдэл				
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	206.00	206.00	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	101.00	88.00	13	87.12
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	88.00	75.00	13	85.22
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00	-	100.00
620004	Гэрээт ажилтан	0.00	0.00	-	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	101.0	88.0	13	87.12
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	89.00	76.00	13	85.39
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12.00	12.00	-	100.00

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 153,021.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Завсарын аудитаар үзсэн ажилчдын цалин олгохдоо ур чадварын нэмэгдэл 7 сараас хойш өгөөгүй 98,000.0 мянган төгрөг нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-тай Нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул залрууллаа.
2. 2025 оны 9 сарын 30-ны байдлаар НДХэлтэст 51,604.7 мянган төгрөгийн өр үүссэн, хувь хүнээс 6,416.3 мянган төгрөг нийт 58,021.0 мянган төгрөгийн авлага өглөгтэй ажилласан нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-тай Нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул залрууллаа.

Аудитаар нийт 66,769.7 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 4,877.3 мянган төгрөгний төлбөрийн акт, 61,892.4 мянган төгрөгийн цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах 5 зөвлөмж өгсөн

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

Ажлаас чөлөөлөгдсөн 6 албан хаагчдад 3,832.9 мянган төгрөгний ажилласан хугацааны ээлжийн амралтын мөнгө илүү олгосон, 1 албан хаагчид 580,294.0 төгрөгийн ээлжийн амралтын цалинг дутуу олгосон, жижүүр Д.Ганбаатарт 8-р сарын цалинг сахилгын шийтгэлийн 20 хувийг бууруулаагүй олгосон 177,3 мянган төгрөг, мөн сахилгын шийтгэлтэй үед 286,8 мянган төгрөгний урамшуулал олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.5 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021-12-06 өдрийн А/191 дугаар тушаалаар баталсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ыг заалтыг зөрчсөн байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

5.3 Зөвлөмж

5.3.1. Авлагын данстай холбоотой асуудал

5.3.1.1 Илрүүлэлт:

Татварын хэлтэс рүү илүү шилжүүлсэн 2,601.4 мянган төгрөг, Театрын цайны газар түрээсийн орлого 1,102.5 мянган төгрөг, 2023.12.27-ны 23-01-23 үүссэн 284.3 мянган төгрөгийн авлага нийт 3,988.2 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" 40 дугаар зүйлийн "70.5.Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно." Гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

5.3.1.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийг зөв зохистой удирдаж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, авлага үүсгэхгүй ажиллах.

5.3.2. Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой асуудал

5.3.2.1 Илрүүлэлт:

Он удаан жил авлагаар бүртгэсэн 4,308.1 мянган төгрөгийг одоо болтол суутгаагагүй мөн Өмнөх аудитаар авлага барагдуулах зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлж ажиллаагүй нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3.2.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийг зөв зохистой удирдаж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, авлага үүсгэхгүй ажиллаагүй тул Хариуцлага тооцох.

5.3.3. Өр төлбөрийн данстай холбоотой асуудал

5.3.3.1 Илрүүлэлт:

Цалингийн зардлаас үлдсэн мөнгийг Татварын хэлтэст илүү шилжүүлсэн, "Сөөм газар" жүжгийн хувцас, тайзны материал болон гэрэлтүүлэг, маркетингийн зардал болон хувь

хүн болон байгууллагад өр үүсгэсэн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нийт 27,675.2 мянган төгрөгийн өр үүсгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" 40 дугаар зүйлийн "70.5.Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно."

5.3.3.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийг зөв зохистой удирдаж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, авлага үүсгэхгүй ажиллах.

5.3.4. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

5.3.4.1 Илрүүлэлт:

Дархан-Уул аймгийн Залуучууд театр 2025 оны Санхүүгийн тайланг УСНББОУС болон Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан шаардлагууд болон Сангийн яамнаас гаргасан заавар журмын дагуу иж бүрэн бэлтгээгүй нь Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 болон Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "...санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ" гэсэн заасан заалтыг зөрчсөн байна.

5.3.4.2 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланг иж бүрэн бэлтгэж цаг хугацаандаа Төрийн аудитын байгууллагад өгөөгүй тул Хариуцлага тооцох

5.3.5. Зардлын данстай холбоотой асуудал

5.3.5.1 Илрүүлэлт:

Жижүүр Х.Цэдэндаш-д ажлаас чөлөөлөгдөхөд нь ажилласан хугацааны ээлжийн амралтын мөнгө 580.3 мянган төгрөгийг дутуу олгосон нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021-12-06 өдрийн А/191 дугаар тушаалаар баталсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ыг 2.8.1 дэх заалтыг зөрчсөн байна

5.3.5.2 Өгсөн зөвлөмж:

Дутуу олгосон ээлжийн амралтын мөнгийг олгох

5.3.5.3 Илрүүлэлт:

Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 25,340.6 мянган төгрөгний зардал бууруулж гүйлгээ хийж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" заалтыг зөрчсөн байна.

5.3.5.4 Өгсөн зөвлөмж:

Зардал бууруулахгүй гүйлгээ хийж байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Завсрын аудитаар ур чадварын нэмэгдэл олгоогүй	1	98,000.0			1	98,000.0	1	98,000.0				
Өглөг авлагатай холбоотой	1	58,021.0			1	58,021.0	1	58,021.0				
Дүн	2	153,021.0			2	153,021.0	2	153,021.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлага үүсгэсэн	1	3,988.2					1	3,988.2				
Ээлжийн амралтын цалин илүү олгосон, сахилгын шийтгэл суутгаагүй, урамшуулал олгосон.	7	4,877.3	1	4877.3								
Ээлжийн амралтын цалин дутуу олгосон	1	580,3					1	580,3				
Өглөг үүсгэсэн	1	27,675.2					1	27,675.2				
Өмнөх аудитын зөвлөмж биелүүлээгүй	1	4,308.1					1	4,308.1				

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Санхүүгийн тайлагналтай холбоотой	1	25,340.6					1	25,340.6				
Дүн	4	66,769.7	1	4,877.3			5	61,892.4				